*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА Г.ГАНХУЯГ-ийн 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Гүйцэтгэлийн түвшин | | Эхэлсэн, дуусган хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (Биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Халдварт бус өвчний сэргийлэлт, хяналтын урт, дунд, богино хугацааны бодлого, хэрэгжилтийн удирдлага, зохицуулалт** | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 1.1<br>ЗГҮАХ 2.3.1.2.391<br>ЭМЯ 43<br>Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хууль сурталчлах | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь, нэлгээний тайлан | 30 (2023 он) | Техникийн ажлын хэсгийг батлах | Тамхины хяналтын тухай хуульд Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн техникийн туслалцаа үзүүлэх Ажлын хэсгийг Эрүүл мэндийн сайдын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/25 дугаар тушаалаар батлуулав.<br>Электрон тамхины зах зээл, маркетингийн судалгааны үр дүн, Тамхины хяналтын тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийг таницуулах дээд түвшний уулзалт, Электрон тамхины зах зээл, маркетингийн судалгааны үр дүнг танилцуулах салбар дундын уулзалт хэлэлцүүлгийг УИХ-ын Тамгын газар, ДЭМБ-тай хамтран тус тус зохион байгуулсан.<br>Тамхины хяналтын тухай хуулийн төсөлтэй холбоотой УИХ-ын Тамгын газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу 11 зүйл, заалттын судалгаа, нотолгоог боловсруулж хүргүүлсэн, УИХТГ-аас хуулийн зардлын тооцоолол хийж буйтай | 2025.01-06.10 | 100% |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Гүйцэтгэлийн түвшин | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (Биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | холбоотой тамхинаас гаргах эм, эмчилгээний талаар мэдээллийг хүргүүлсэн..<br>Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжүүлэх асуудлаар харьяа байгууллагуудад албан бичиг хүргүүлж, саналуудыг хамтран ажиллаж байна.<br>Дэлхийн тамхигүй өдрийг тэмдэглэн өнгөрөөх өдөрлөгийг Тамхины үнэнийг илчилье сэдвийн хүрээнд залуучуудад чиглэсэн арга хэмжээг Улаанбаатар цэцэрлэгт хүрээлэнд ДЭМБ, ЕТГ, СЭМҮТ, НЭМҮТ, УГТЭ, ХСҮТ, Азийн анагаахын оюутны холбоотой хамтран зохион байгуулав. | | |
| 2 | Арга хэмжээ 1.2<br>ЗГҮАХ 2.1.1.2.166<br>ЭМЯ 3<br>Гэр бүлийг дэмжих тухай хуулийг батлуулж хэрэгжүүлэх | Хуульд тусгуулсан заалтын тоо | 0 | Гэр бүлийг дэмжих тухай хуулийн төсөлд санал өгсөн байна. | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас санаачлан боловсруулсан “Гэр бүлийг дэмжих тухай” анхдагч хуулийн төсөлд санал өгч 2025.06.02-ны өдөр Хуулийн хэлтсээс ирүүлсэн Дотоод меморандум №196 хариуг хүргүүлсэн. Үүнд:<br>1. Хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн “Эрүүл мэндийг дэмжих” хэсгийн 11.1.3, 11.1.4, 11.1.5, 11.1.6, 11.1.7 заалтуудыг өөрчлөн найруулахаар;<br>2. Төслийн 11.1.8, 11.1.9, 11.1.10, 11.1.11 заалтуудыг шинээр нэмэхээр. Үүнд:<br>• Төсөлд 11.1.8 дахь заалт болгон “Жирэмсэн эх, 5 хүртэл насны хүүхдэд өгөх олон найрлагат бичил тэжээл, амин дэм, хоол тэжээлийн багц гарган сурталчлан таниулж, түгээх” хэмээн нэмж оруулах; | 2025.01-06.10 | 100% |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Гүйцэтгэлийн түвшин | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (Биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | • Төсөлд 11.1.9 дэх заалт болгон "Хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлд гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг нэн тэргүүнд хүргэх" хэмээн нэмж оруулах;<br>• Төсөлд 11.1.10 дахь заалт болгон "Үргүйдэлтэй гэр бүлд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг ойртуулж, нийгэм, сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх" хэмээн нэмж оруулах;<br>• Төсөлд 11.1.11 дэх заалт болгон "Гэр бүлийг идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр хичээллэх багцыг бий болгож эрүүл мэндийн даатгалын сантай уялдуулах" хэмээн нэмж оруулах; | | |
| 3 | Арга хэмжээ 1.3<br>"Сэтгэцийн эрүүл мэнд" зорилтот арга хэмжээний төлөвлөгөө /2024-2027/-г хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэх | Эрүүл мэндийн сайдын тушаал | 20% | 30% | Сэтгэцийн эрүүл мэнд арга хэмжээг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний тайланг хавсаргав. | 2025.01-06.10 | 100% |
| 4 | Арга хэмжээ 1.4<br>ЗГҮАХ 2.3.1.3<br>МУХТЖҮЧ 2.2.2<br>МУХТ 3.1.1<br>ЭМЯ 53<br>Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах "Эрүүл Монгол хүн" арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, батлуулах | Эрүүл мэндийн сайдын тушаал | - | Арга хэмжээ, төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийн тушаал батлуулж, арга хэмжээ, төлөвлөгөө төслийг боловсруулсан байна. | Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах "Эрүүл Монгол хүн" арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг Эрүүл мэндийн сайдын 2025 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн А/64 дүгээр тушаалыг батлуулсан. Арга хэмжээ, төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийн нарийвчилсан төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Ажлын хэсгийн уулзалтыг биечлэн болон цахим хэлбэрээр 6 удаа зохион байгуулж, төлөвлөгөөг хэлэлцүүлсэн. Арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төслийг боловсруулсан. | 2025.01-06.10 | 100% |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Гүйцэтгэлийн түвшин | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (Биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 5 | Арга хэмжээ 1.5<br>МУХТЖҮЧ 2.2.2<br>ЗГҮАХ 2.3.1.3.396<br>МУХТ 3.1.1.1<br>ЭМЯ 54<br>''Эрүүл Шүд'' арга хэмжээний төлөвлөгөө (2024-2027)-ний хэрэгжилтийг хангах | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь /40%/ | Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын хамтарсан 2024 оны 01 сарын 19-ний А/27А/25 дугаар тушаал | 2025 онд үйл ажиллагааны хэрэгжилт 20%-д хүрсэн байна | Эрүүл мэндийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А/27/А25 дугаар хамтарсан тушаалаар "Эрүүл шүд арга хэмжээний төлөвлөгөө"-г 2024-2027 онд хэрэгжүүлэхээр баталж, 6 зорилтын хүрээнд 40 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.<br>Тус арга хэмжээний хэрэгжилтийн хувь 40%-тай. | 2025.01-06.10 | 100% |
| 6 | Арга хэмжээ 1.6<br>ЗГҮАХ 2.1.1.9.181<br>ЭМЯ 6<br>“Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээг 2025-2028 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө батлуулах | Эрүүл мэндийн сайдын тушаал | Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/760 дугаар тушаал | Арга хэмжээний төлөвлөгөөний төсөл боловсруулагдсан байна | Эрүүл мэндийн сайдын 2024.11.25-ны өдрийн А/465 дугаар тушаалаар "Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд” 2025-2028 онд хэрэгжих арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан, батлуулах ажлын хэсэг байгуулагдан “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээг 2025-2028 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний төслийг 5 зорилтын хүрээнд 81 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр Эрүүл мэндийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/219 тоот тушаалаар батлуулсан.<br>Арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд санал авах хэлэлцүүлэг, уулзалтыг 3 удаа зохион байгуулж хийсэн. Үүнд:<br>1. 2025.04.29-ний өдөр ЭМДЕГ, ЭМХТ, ЭХЭМҮТ, ЭНЭҮТ-II, НЭМҮТ, СЭМҮТ, ГССҮТ, АӨСҮТ, ХӨСҮТ, ХТС, Интермед эмнэлэг, Гурван гал нэгдсэн эмнэлэг, НЭМГ, амаржих газрууд, АШУҮИС, | 2025.01-06.10 | 100% |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Гүйцэтгэлийн түвшин | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (Биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | нийгэмлэг, холбоод, олон улсын байгууллагуудын төлөөлөл болох нийт 45 удирдах албан тушаалтан, эмч, эмнэлгийн мэргэжилтэн нарын дунд; /2025.04.24-ний өдрийн 6/2013 тоот албан бичиг ЭМБ-уудад хүргүүлсэн/.<br>2. 2025.01.28-ны өдөр ЭМДЕГ, ЭМХТ, ЭХЭМҮТ, ЭНЭҮТ-II, НЭМГ, амаржих газрууд, АШУҮИС, дүүргийн ЭМТ-үүдийн удирдлага болон холбогдох эмч, мэргэжилтэн нар болон олон улсын байгууллагын төлөөлөл, ажлын хэсгийн гишүүд болох нийт 50 хүн; /2025.01.24-ний өдрийн 6/384 тоот албан бичгээр ЭМБ-уудад хүргүүлсэн/.<br>3. 2025.04.17-ны өдөр Аймгийн ЭМГ-ын нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга, эх, хүүхэд болон хоол тэжээлийн асуудал хариуцсан мэргэжилтэн, эх барих, эмэгтэйчүүдийн эмч, хүүхдийн эмч нар оролцуулсан хэлэлцүүлгийг 80 хүн оролцосон уулзалт, хэлэлцүүлгийг тус тус зохион байгуулсан. | | |
| 7 | Арга хэмжээ 1.7<br>ЗГҮАХ 2.1.1.14.187<br>ЭМЯ 7<br>“Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд” арга хэмжээг 2025-2028 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө батлуулах | Эрүүл мэндийн сайдын тушаал | Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/559 дүгээр тушаал | Арга хэмжээний төлөвлөгөөний төсөл боловсруулагдсан байна | Эрүүл мэндийн сайдын 2025.02.28-ны өдрийн А/65 дугаар тушаалаар "Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд” 2025-2028 онд хэрэгжих арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан, батлуулах ажлын хэсгийг УНТЭ-УАТ, ЭХЭМҮТ, НЭМҮТ, СЭМҮТ, ЭМХТ, ХЗДХЯ, ЖҮХ, ТТАХЭ, ЦТЭ, ОУБ-уудын төлөөлөл болох нийт салбар дундын төлөөлөл оролцсон 18 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Ажлын хэсгийн хурлыг 2025.03.19-ний өдөр зохион байгуулсан. | 2025.01-06.10 | 100%<br>30%. төлөвлөгөөний төсөл боловсруул-алт |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Гүйцэтгэлийн түвшин | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (Биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | "Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд" 2025-2028 онд хэрэгжих арга хэмжээний төлөвлөгөөг ажлын хэсэг 3 дэд хэсэгт хуваагдан ажиллаж байгаа бөгөөд одоогийн байдлаар 4 зорилтын хүрээнд 38 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөгөөний эхний төсөл гарсан. | | |
| 8 | Арга хэмжээ 1.8<br>Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хууль 15.3<br>ЭМЯ 36<br>Эхийн сүүний нөөцийн банк байгуулж, ажиллуулах журмыг боловсруулж батлуулах | Эрүүл мэндийн сайдын тушаал | Журмын төсөл боловсруулж байгууллагуудаас санал авсан | - | Эхийн сүүний нөөцийн банк ажиллуулах журмын төслийг боловсруулах бэлтгэл ажлын хангаж шаардлагатай материал цуглуулах хүрээнд ДЭМБ-ын Зүүн өмнөд Азийн "Эхийн сүүний банкны стандарт"-ыг орчуулсан. Эхийн сүүний нөөцийн банкны журмын төсөл боловсруулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор ЭМЯ, НЭМҮТ, НҮБ-ын Хүүхдийн сангийн төлөөллийг оролцуулсан уулзалт зохион байгуулж, ажлын төлөвлөгөө гаргасан. Журмын эхний төслийг боловсруулж, холбогдох газруудаас санал авах албан бичгийг хүргүүлсэн. ЭХЭМҮТ, ЭНЭҮТ-2, Өргөө, Хүрээ амаржих газрууд, Интермед эмнэлгээс ирүүлсэн саналыг тусган боловсруулж, удирдлагуудаас санал авч тусган эрүүл мэндийн сайдын төсөлд газар хэлтсийн дарга нараар саналыг аван эрүүл мэндийн сайдаар батлуулахад бэлэн болоод байна | 2025.01-06.10 | 70% |
| 9 | Арга хэмжээ 1.9<br>Нүүр амны тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах, халдвараас сэргийлэх үйл ажиллагааны заавар батлуулах | Эрүүл мэндийн сайдын тушаал | Зааврын төсөл 70%-тай | Хэлэлцүүлэг зохион байгуулсан байна | ''Нүүр амны тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах, халдвараас сэргийлэх үйл ажиллагааны заавар''-ын төслийн хэлэлцүүлгийг ЭМЯ-ны Б зааланд 2025 оны 4-р сарын 24-ний өдрийн 14:00-17:30 цагийн хооронд нүүр ам судлалын салбарын болон халдвар хамгааллын чиглэлийн эмч мэргэжилтэн | 2025.01-04.24 | 100% |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Гүйцэтгэлийн түвшин | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (Биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | нийт 70 хүнийг хамруулан зохион байгуулсан. Тус хэлэлцүүлгээс гарсан саналыг тусган https://moh.gov.mn/news/7312 вэбсайтад нэмэлтээр санал авахаар байршуулсан. | | |
| 10 | Арга хэмжээ 1.10 Амны хөндийн эрүүл мэндийн үндэсний зөвлөгөөнийг зохион байгуулах | Зохион байгуулсан зөвлөгөөн | НАС-ын анхдугаар чуулган | НАС-ын II чуулган зохион байгуулсан байна | “Эрүүл шүд- эрүүл ирээдүй” нүүр ам судлалын салбарын II зөвлөгөөнийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор 2025 оны 03 сарын 20,21-ний өдрүүдэд зохион байгуулсан. Тус зөвлөгөөнийг зохион байгуулах ажлын удирдамж, хөтөлбөрийг Эрүүл мэндийн сайдаар батлуулж зохион байгуулалтын ажлыг хангаж салбар бүрийн төлөөлөл болох нийт 500 оролцогчийг хамруулан зохион байгуулав. | 2025.03.21-03.22 | 100% |
| 11 | Арга хэмжээ 1.11 ДЭМБ-ын зөвлөмжийн дагуу “Химийн бодисын замын зураглал”-ыг төлөвлөгөөг өөрийн орны онцлогт тохируулан боловсруулж, батлуулах | Эрүүл мэндийн сайдын тушаал | “Химийн бодисын замын зураглал” арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө (2025-2028)-ний төслийг 4 зорилт, 32 үйл ажиллагааг 18 шалгуур үзүүлэлттэйгээр эцэслэн боловсруулсан. Уг арга хэмжээний төлөвлөгөөн | “Химийн бодисын замын зураглал” арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө (2025-2028)-г боловсруулах | Эрүүл мэндийн сайдын “Ажлын хэсэг байгуулах тухай” А/159 дүгээр тушаалаар Химийн бодисын замын зураглал боловсруулах ажлын хэсгийг 21 байгууллагын 36 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Ажлын хэсгийн уулзалт, хэлэлцүүлгийг 2024 оны 5, 7, 11 дүгээр саруудад 3 удаа зохион байгуулж, холбогдох чиг үүргийн 30 гаруй албан тушаалтан, мэргэжилтнүүд оролцож 3 төрлийн үнэлгээ, 4 чиглэлээр дүн шинжилгээг хийж, “Химийн бодисын замын зураглал” арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө (2025-2027)-ний төслийг 4 зорилт, 32 үйл ажиллагааг 18 шалгуур үзүүлэлттэйгээр эцэслэн боловсруулсан. Уг арга хэмжээний төлөвлөгөөний төслийг тойрох хуудсаар ЭМЯ-ны | 2025.01-06.10 | 100% |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Гүйцэтгэлийн түвшин | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (Биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | ий төслийг тойрох хуудсаар ЭМЯ-ны удирдлагуудад танилцуулж, санал авч байна. | | удирдлагуудад танилцуулж, санал авч байна. | | |
| 12 | Арга хэмжээ 1.12<br>АХ-2050, зорилт 2.2.8, МУХТЖҮЧ- 2.2.2, ЗГҮАХ 2.3.1.2,<br>ЭМЯ 48-2<br>“Орчны эрүүл мэнд” 2025-2028 арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах | Эрүүл мэндийн сайдын тушаал | “Орчны эрүүл мэнд” 2021-2024 арга хэмжээний төлөвлөгөө хэрэгжилт | Ажлын хэсгийн тушаал батлуулж, төлөвлөгөөний төсөл боловсруулсан байна. | Орчны эрүүл мэндийн төлөвлөгөө боловсруулахад Төрийн нарийн бичгийн даргын 2/1343 дугаар албан бичгээр 2025 оны 3 дугаар сарын 19-ний өдөр холбогдох байгууллагуудаас ажлын хэсэгт нэр авч, Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/166 дугаар тушаалаар 21 хүний бүрэлдэхүүнтэй салбар хоорондын ажлын хэсгийг байгуулсан.<br>Тус ажлын хэсэг 2 удаа биеэр, 1 удаа цахимаар хуралдаж төлөвлөгөөний төслийг эхний байдлаар боловсруулаад байна.<br>2025 оны 3 дугаар улиралд багтаан өргөтгөсөн хэлэлцүүлэг хийж арга хэмжээний төлөвлөгөөг сайдын тушаалаар батлуулахаар ажиллаж байна. | 2025.01-06.10 | 100% |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Гүйцэтгэлийн түвшин | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (Биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 13 | Арга хэмжээ 1.13<br>ЗГҮАХ 2.3.1.2.392<br>ЭМЯ 48-3<br>“Эрүүл ажлын байр” арга хэмжээ боловсруулж батлуулах | Эрүүл мэндийн сайдын тушаал | | Арга хэмжээ, төлөвлөгөөг боловсруулах, ажлын хэсгийн тушаал батлуулж, арга хэмжээ, төлөвлөгөө төслийг боловсруулсан байна. | Арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсуулаагүй. | 2025.01-06.10 | 0 |
| 14 | Арга хэмжээ 1.14<br>Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх “Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт”-ын хэрэгжилтийг хангах, төлөвлөгөөний төсөлд санал өгсөн байх<br>NDC3.0 | Салбарын хэлэлцүүлэг зохион байгуулж, төлөвлөгөөнд санал тусгасан байх | NDC2.0 | Салбарын хэлэлцүүлэг зохион байгуулж төлөвлөгөөний төсөл боловсруулсан байна | Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хэрэгжүүлэх урт хугацааны хөгжлийн стратеги боловсруулах салбар дундын ажлын хэсэгт орж ажилласан.<br>Эрүүл мэндийн салбарын хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулан.<br>Төлөвлөгөөний төслийг 2025 оны 5 дугаар сарын 07-ны өдөр эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ТББ, нийгэмлэгийг хамруулан 40 гаруй төлөөллийг оролцуулан зохион байгуулсан.<br>Монгол Улс Парисын хэлэлцээрээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх “Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН)”-ийн зорилтыг ахиулан шинэчлэх үүрэг бүхий 11 дэд ажлын хэсэг байгуулан олон улсын түнш байгууллагын дэмжлэгтэйгээр тус баримт бичгийг 2025 оны 06 дугаар сард Засгийн газраар хэлэлцүүлэн, батлуулахаар төлөвлөн ажиллаж байна. | 2025.01-06.10 | 100% |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Гүйцэтгэлийн түвшин | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (Биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 2. Халдварт бус өвчний сэргийлэлт, хяналтын чиглэлийн хууль, тогтоомж, стандарт, заавар, нэгдэн орсон олон улсын конвенцын хэрэгжилтийн удирдлага, зохицуулалт, нэгдсэн тайлагналт** | | | | | | | |
| 16 | Арга хэмжээ 2.2 Хог хаягдлын тухай хууль 8.3.2 ЭМЯ 32 Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах журам, аргачлал, зааврыг шинэчлэн батлуулах | Эрүүл мэндийн сайдын тушаал | Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/505 дугаар тушаал | Эрүүл мэндийн сайдын тушаал батлуулж, эрх зүйн хэм хэмжээний актад бүртгүүлсэн байна. | Эрүүл мэндийн сайдын 2025 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн А/173 дугаар тушаал батлуулж, 2025 оны 21-ний өдөр 7259 дугаарт Захиргааны хэм хэмжээний актын бүртгэлд бүртгүүлсэн. Мөн актаас бусад эмнэлгийн хог хаягдлыг зохицуулах журмыг Эрүүл мэндийн сайдын 2025 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн А/193 дугаар тушаалаар батлуулсан. | 2025.01-06.10 | 100% |
| 17 | Арга хэмжээ 2.3 Эрүүл ахуйн тухай хууль 4.5 ЭМЯ 34 Хүн, мал, амьтанд тараах, байгаль орчинд аюултай хог хаягдлын жагсаалт, булшлах, устгах аргачлалыг боловсруулж батлуулах | Эрүүл мэнд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын хамтарсан тушаал | - | - | Хугацаа болоогүй | 2025.01-06.10 | - |
| **Зорилт 3. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах, тайлагналт** | | | | | | | |
| 18 | Арга хэмжээ 3.1 ЗГҮАХ 2.3.1.4.400 ЭМЯ 58 Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх дэд төв, нийгмийн эрүүл | Эрүүл мэндийн сайдын тушаал | | Холбогдох судалгаа хийх, бүтэц, дүрмийн төслийг боловсруулсан байна. | Холбогдох судалгааг хийж, аймаг, дүүргийн НЭМТ, сум, ӨЭМТ, ЭМБ-ны НЭМ-ийн алба, нэгжийн бүтцийн төслийг боловсруулсан. | 2025.01-06.10 | 100% |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Гүйцэтгэлийн түвшин | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (Биелэлт) | | |
| 1 | | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | мэндийн төвийн бүтэц дүрмийг батлуулна. | | | | | | |
| 19 | Арга хэмжээ 3.2 НЭМТҮ-ийн орон тооны бус үндэсний Зөвлөлийн ажиллах журам боловсруулж, батлуулах | Батлагдсан журам | НЭМТҮ-ийн орон тооны бус үндэсний Зөвлөлийн бүрэлдэхүүн батлагдсан. | Журмыг боловсруулах | НЭМ-ийн орон тооны бус үндэсний Зөвлөлийн ажиллах журам боловсруулсан. | 2025.01-06.10 | 100% |
| 20 | Арга хэмжээ 3.3 НЭМТҮ-нд олон нийтийн оролцоог хангах, сайн дурын ажилтныг урамшуулах журам | Эрүүл мэндийн сайдын тушаал | - | - | Хугацаа болоогүй | 2025.01-06.10 | - |
| **Зорилт 4. Эрт илрүүлгийн арга хэмжээний зохион байгуулалтын удирдлага, зохицуулалт** | | | | | | | |
| 21 | Арга хэмжээ 4.1 Нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгт зорилтот бүлгийн хүн амыг хамруулах журмыг шинэчлэн боловсруулах, батлуулах | Батлагдсан журам | Эрүүл мэндийн сайдын 379 дугаар тоот тушаал | Журмыг батлуулсан байна. | Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/04 дүгээр Журам шинэчлэн батлах тухай тушаал батлуулав. | 2025.01-06.10 | 100% |
| 22 | Арга хэмжээ 4.2 Эрт илрүүлэг 2.0 арга хэмжээ, хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж батлуулах | Батлагдсан төлөвлөгөө | | - | Хугацаа болоогүй | 2025.01-06.10 | - |
| 23 | Арга хэмжээ 4.3<br>МУХТЖҮЧ 2.2.2<br>МУХТ 3.1.1<br>ЗГҮАХ 2.3.1.1.387<br>ЭМЯ 19<br>Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн | ЗГҮАХ-ийн хүрэх түвшин /илрүүлгийн хамрагдалтын хувь/ | Хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан хүн амын хувь | - | Хугацаа болоогүй | 2025.01-06.10 | - |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Гүйцэтгэлийн түвшин | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (Биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | үзлэг 2.0 арга хэмжээг хэрэгжүүлэх | | Нярайн эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтын хувь | - | | | |
| | | | Сургуульд суурилсан эрт илрүүлгийн үзлэгийн хувь | - | | | |
| **Зорилт 5. Сургуулийн эрүүл мэнд, аюулгүй байдлын бодлого, хэрэгжилтийн нэгдсэн удирдлага, зохицуулалт** | | | | | | | |
| 24 | Арга хэмжээ 5.1<br>ЗГҮАХ 2.3.1.2.393<br>МУХТЖҮЧ 2.2.2<br>МУХТ 3.1.1<br>ЭМЯ 48-1<br>Эрүүл аюулгүй сургууль арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, батлуулах, хэрэгжүүлэх | Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдын хамтарсан тушаал | - | Арга хэмжээ, төлөвлөгөөг батлуулсан байна. | Эрүүл аюулгүй сургууль арга хэмжээ, арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2025-2028 оны төлөвлөгөөг ЭМС, БС-ын хамтарсан 2025.02.06-ны өдрийн А/53, А/37 дугаар тушаалаар батлуулав. | 2025.01-06.10 | 100% |
| 25 | Арга хэмжээ 5.2<br>ЗГҮАХ 2.2.1.14.332<br>ЭМЯ 17<br>2024-2025 оны хичээлийн жилд ЕБС-ийн 6 настнуудад зүрх, нүд, шүдний эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулах | Илрүүлгийн хувь | 32.5% | 50% | Улсын хэмжээнд 6 настны эрт илрүүлгийн хамрагдалт 94.33 хувь.<br>Нийслэлийн ЕБС-ийн 6 настны эрт илрүүлгийн үзлэг нийт 40,753 хүүхдийн 89.69% нь хамрагдсан байна. Үүнээс зүрхний цахилгаан бичлэгийн өөрчлөлт 21.35%, шүдний цоорол, гажиг 90%, харааны өөрчлөлт 20.4% -д тус тус илэрсэн бөгөөд дараагийн шатны оношилгоо, эмчилгээний явц 17-72%-тай явж байна. https://eruulhuuhed.mn/mainDashboard<br>Орон нутгийн 6 настны эрт илрүүлгийн үзлэг нийт 38,723 хүүхдийн 98.96% нь | 2025.01-06.10 | 100% |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Гүйцэтгэлийн түвшин | | Эхэлсэн, дуусссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (Биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | хамрагдсан байна. Үүнээс зүрхний цахилгаан бичлэгийн илрүүлэгт 93.4% орж зүрхний бичлэгийн өөрчлөлт 18.91% гарч 42.11% нь эхо шинжилгээнд, шүдний илрүүлэгт 93.3% орж, шүдний цоорол, гажиг 68.14% илэрч, 91.75% нь эмчлүүлээд байна. Хараaны илрүүлэгт 85.6% хамрагдаж, харааны өөрчлөлт 15.1% -д тус тус илэрсэн. https://aimag.eruulhuuhed.mn/mainDashboard | | |
| 26 | Арга хэмжээ 5.3 Хөдөө орон нутгийн ЕБС-ийн 6 настнуудад зүрх, нүд, шүдний эрт илрүүлгийн үзлэг хийх эмч эмнэлгийн мэргэжилтнүүд, сургуулийн эмч, нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах сургалт зохион байгуулах | Сургалтад хамрагдсан хүний тоо | - | Зүрх, нүд, шүд 3 чиглэлээр үзлэг хийх нийслэлийн эмч эмнэлгийн мэргэжилтнүүд, сургуулийн эмч, нийгмийн ажилтнуудад сургалт зохион байгуулсан байна. | Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн суралцагчдад хараа шалгах, зүрхний эмгэгийг илрүүлэх, шүдний эрт илрүүлэг хийх эмч, сувилагч, шүдний эмч, шүдний эмчийн туслах, сургуулийн эмч, нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах сургалтын удирдамж, хөтөлбөрийг батлуулж сургалтыг зохион байгуулав. 6 настны эрт илрүүлгийн хүрээнд нийслэл, орон нутгийн Эрүүл мэндийн газар, Боловсролын газар, анхан шатны эрүүл мэндийн байгууллагын 1100 гаруй эмч, сувилагч, мэргэжилтэн, улсын болон хувийн шүдний 580 гаруй эмнэлгийн эмч, техникч, харааны илрүүлэг хийх 1000 орчим ЕБС-ийн эмч, нийгмийн ажилтан, оношилгоо эмчилгээ хийх 21 аймгийн эмч нарыг чадавхжуулсан. 6 настны эрт илрүүлгийн хүний нөөцийг чадавхжуулах цогц сургалтыг Эрүүл мэндийн яам, Боловсролын яам, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Боловсролын | 2025.01-06.10 | 100% |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Гүйцэтгэлийн түвшин | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (Биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | ерөнхий газар, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нүүр ам судлалын сургууль, Орбис олон улсын байгууллагаас зохион байгуулсан. | | |
| 27 | Арга хэмжээ 5.4<br>ЭМЯ 29<br>Сургуулийн орчин дахь суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах тухай анхдагч хуулийн үзэл баримтлалыг батлуулж, хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ. | Засгийн газрын шийдвэр | - | Хуулийн төсөл, хуулийн үзэл баримтлалын төслийг боловсруулсан байна. | Сургуулийн орчин дахь суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах тухай анхдагч хуулийн үзэл баримтлалыг боловсруулав. | 2025.01-06.10 | 100% |
| **Зорилт 6. Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилтээр хэрэгжих төсөл, арга хэмжээтэй холбоотой нэгдсэн удирдлага, зохицуулалт** | | | | | | | |
| 28 | Арга хэмжээ 6.1<br>Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээний 2025 оны тэргүүлэх чиглэл батлах тухай журам | Эрүүл мэндийн сайдын тушаал | Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/396 дугаар тоот тушаал | Эрүүл мэндийн сайдын тушаал | Эрүүл мэндийн сайдын 2025 оны 03 дугаар сарын сарын 31-ний өдрийн "Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээний 2025 оны тэргүүлэх чиглэл батлах тухай" А/100 дугаар тоот тушаалаар нийгмийн эрүүл мэндийн төсөл арга хэмжээний тэргүүлэх чиглэлийг батлуулсан. | 2025.01-06.10 | 100% |
| **Зорилт 7. Уламжлалт анагаах ухааны нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бодлого, хэрэгжилтийн нэгдсэн зохион байгуулалт, зохицуулалт** | | | | | | | |
| 29 | Арга хэмжээ 7.1<br>Ард иргэдэд уламжлалт анагаах ухаан аргаар өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих чиглэлээр мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагаа зохион байгуулах | Зохион байгуулсан мэдээлэл, сурталчилгааны тоо | - | МС-ны үйл ажиллагаа 1 удаа зохион байгуулсан байна. | Ард иргэдэд уламжлалт анагаах ухаан аргаар өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих чиглэлээр олон нийтэд чиглэсэн мэдээлэл сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөр дамжуулан зохион байгуулсан. Тайланг хавсаргав. | 2025.01-06.10 | 100% |
| **Зорилт 8. Халдварт бус өвчний чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийн зохицуулалт, тайлагналтын удирдлага** | | | | | | | |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Гүйцэтгэлийн түвшин | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (Биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 30 | Арга хэмжээ 8.1<br>ЗГҮАХ 2.3.1.3.399<br>МУХТЖҮЧ 2.2.2<br>МУХТ 3.1.1<br>ЭМЯ 56<br>Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөө хэрэгжүүлэх | ЗГҮАХ-ийн хүрэх түвшин /хэрэгжилтийн хувь/ | 30 (2023 он) | | Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг хавсаргав. | 2025.01-06.10 | |
| 31 | Арга хэмжээ 8.2<br>ДЭМБ-ын МонПЭН санаачилгын хүрээнд ХБӨ/ЗСӨ-өөс сэргийлэх, хянах нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багцыг нэвтрүүлж хэрэгжүүлж эхлэх | МонПЭН нэвтэрсэн аймаг дүүргийн тоо | 14 аймаг, 3дүүрэгт хэрэгжиж байна. | 6 дүүрэгт нэвтэрч, хэрэгжсэн байна. | Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул, Налайх, Багахангай дүүргийн 112 өрхийн эрүүл мэндийн төвд төвд ДЭМБ-ын ХБӨ/ЗСӨ-ий урьдчилан сэргийлэлт, хяналтын нэн шаардлагатай тусламж үйлчилгээний багц (PEN/HEARTS)-ыг нэвтрүүлсэн. Сургалтын хөтөлбөрийг шинэчлэн 2025 оны 12 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулагдсан. Сургалтад нийт 60 гаруй оролцогчид хамрагдсан. 2025 оны 1 дүгээр сарын 28-31-ний өдрүүдэд Баянзүрх, Чингэлтэй, Хан-Уул, Сүхбаатар, Налайх, Багахангай дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгийн эмч, удирдлага, холбогдох мэргэжилтнүүд, АШЭМБ- эмч, мэргэжилтнүүд нийт 325 оролцогчдод МОНПЭН хэрэгжүүлэх арга зүйн сургалт зохион байгуулагдсан. Эрүүл мэндийн байгууллагуудын удирдлагууд НЗДТГ, дүүргүүдийн ЗДТГ-ын удирдлага, холбогдох албан тушаалтнуудтай ХБӨ-ийг бууруулах чиглэлээр нээлттэй хэлэлцүүлэг хийсэн. | 2025.01-06 | 100% |
| 32 | Арга хэмжээ 8.3 | Батлагдсан удирдамж, | 2024 онд үйл ажиллагаа | - | Хугацаа болоогүй | 2025.01-06 | |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Гүйцэтгэлийн түвшин | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (Биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | Оюутны эрүүл мэндийг дэмжих аяныг зохион байгуулах | хөтөлбөр | зохион байгуулсан | | | | |
| 33 | Арга хэмжээ 8.4<br>ЗГҮАХ 2.3.10.1<br>Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын стандартын хэрэгжилтийг хангахад хамтран ажиллах, Сургуулийн хүнсний орчныг сайжруулах | Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан | "MNS 7005: 2023 Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих шаардлага | Стандартыг хэрэгжүүлэхэд хамтран ажилласан байна | "MNS 7005: 2023 Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих шаардлага" стандартын дагуу ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөгдөж буй хууль тогтоомж, стандартын хэрэгжилтэд хяналт тавьж байна. 138 ерөнхий боловсролын сургуулиас аймгийн 76, нийслэлийн 8 сургууль буюу 60.9 хувийг хамруулан үдийн хоолны илчлэг, шим тэжээллийн байдлыг үнэлгээ хийсэн. Хяналт шалгалтад хамрагдсан ерөнхий боловсролын сургуулийн 27.4% нь хоол зүйчтэй, 74.0% нь хүүхдийн хоолны чиглэлээр мэргэшсэн тогоочтой, 89.0% нь хоолны технологийн карттай, 93.2% нь хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг гэрээт компаниас бэлтгэн нийлүүлдэг, 50.7% нь түүхий эд, бүтээгдэхүүний шинжилгээний бичигтэй, 86.3% нь тоног төхөөрөмж хүрэлцээтэй байна. | 2025.01-06 | 100% |
| 34 | Арга хэмжээ 8.5<br>Амны хөндийн эмгэгийн илрүүлэг, оношилгоонд дижитал технологийн хэрэглээ, инновац нэвтрүүлэх | Инновацыг нэвтрүүлсэн байна | - | Инновац, дижитал технологийн хэрэглээг нэвтрүүлэх суурь бэлтгэл ажлыг хангасан байна | "Эрүүл шүд" арга хэмжээний зорилтыг хангаж ажиллахын хүрээнд Бүгд Найрамдах Солонгос Улсад сургуулийн өмнөх боловсролын байгууллагад болон анхан шатны байгууллагуудад шүдний эрт илрүүлгийн үзлэгийг дижитал технологи ашиглан хэрхэн хэрэгжүүлж буй туршлага судлах, танилцах уулзалтад ТНБД-ын 2025 оны 5 дугаар | 2025.01-06 | 100% |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Гүйцэтгэлийн түвшин | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (Биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | сарын 30-ны өдрийн гадаад уулзалтад оролцох тухай тушаалын хүрээнд Бүгд Найрамдах Солонгос Улсад 2025 оны 6 дугаар сарын 2-ны өдрөөс 6 дугаар сарын 6-ны өдрүүдэд туршлага судлан ирсэн ба тус дижитал технологийг хэрэглээг туршилтын журмаар нэвтрүүлэхээр төлөвлөлтийг зохион байгуулахаар ажиллаж байна. | | |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | |
| 35 | Тендерийн сонгон шалгаруулалт | Тоо | - | Тендерийн сонгон шалгаруулалтыг хийсэн байна. | Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, Глобаль сан, Эрүүл мэндийн яамнаас зохион байгуулсан 14 тендерийг сонгон шалгаруулсан. | 2025.01-06.10 | 100% |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 2.1<br><br>Ажил үүрэгтэй холбоотой мэдлэг, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдах | Сургалтад хамрагдсан байх | - | Сургалтад хамрагдсан байх | -БНХАУ-ын Хөх хотод зохион байгуулагдсан Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, анхны тусламж үзүүлэх сургалтад 2025.05.10-18-ны өдрүүдэд хамрагдсан.<br>-Колумб Улсад зохион байгуулагдсан Агаарын бохирдол ба эрүүл мэнд сэдэв олон улсын бага хуралд оролцсон. | 2025.01-06.10 | |
| 2. | Арга хэмжээ 2.2<br><br>Хувь хүний хөгжлийн сургалтад хамрагдах | Сургалтад хамрагдсан байх | - | Сургалтад хамрагдсан байх | Удирдлагын хөгжлийн академийн Нийгмийн удирдлагын тэнхимд Докторын сургалтад сурсан. | 2025.01-06.10 | |

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:

Халдварт бус өвчний хэлтсийн дарга ................................ / Г. Ганхуяг/ 2025 оны 6 дугаар сарын 15